



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН
ТУШААЛ

2025 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/362

Улаанбаатар хот

Эрдэм шинжилгээний сэтгүүлийн журам
батлах тухай

ШУТИС-ийн дүрмийн 4.9.16 дахь заалт, Эрдэм шинжилгээ, технологийн дэд зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хурлын тэмдэглэл, ШУТИС-ийн ректорын зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1 “MUST Journal of Science and Technology” эрдэм шинжилгээний сэтгүүлийн журмыг хавсралтаар баталж, 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2 “MUST Journal of Science and Technology” эрдэм шинжилгээний сэтгүүлийг олон улсын цувралын дугаар бүхий индексжүүлсэн бүртгэлтэй болгож, холбогдох шаардлагыг хангасан бүтээлүүд нийтэлж, нийтийн хүртээл болгох ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэхийг Эрдэм шинжилгээ, технологи хөгжүүлэлтийн алба (Ц.Цоггэрэл)-д даалгасугай.

3 Сэтгүүлийн редакцын зөвлөлийг байгуулж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, инновац эрхэлсэн проректор (Д.Цолмонбаатар)-т үүрэг болгосугай.

РЕКТОР



Т.НАМНАН

367011732

ШУТИС-ийн ректорын 2025 оны 11 дүгээр сарын
10-ны өдрийн 4/36 дугаар тушаалын хавсралт



	“MUST JOURNAL OF SCIENCE AND TECHNOLOGY” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЭТГҮҮЛИЙН ЖУРАМ ШУТИС-ЭШ-ЖУ...	Эхний хэвлэлт	2025.11.10
		Өөрчилсөн огноо	
		Өөрчлөлтийн дугаар	

“MUST JOURNAL OF SCIENCE AND TECHNOLOGY” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЭТГҮҮЛИЙН ЖУРАМ

Боловсруулсан:

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ТЕХНОЛОГИ ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЛБА

Хянасан:

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ТЕХНОЛОГИЙН ДЭД ЗӨВЛӨЛ

Дэмжсэн:

ШУТИС-ийн РЕКТОРЫН ЗӨВЛӨЛ

Баталсан:

ШУТИС-ийн Ректор



АГУУЛГА.....	2
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....	3
ХОЁР. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЭТГҮҮЛД НИЙТЛҮҮЛЭХ БҮТЭЭЛИЙН ТӨРӨЛ, БҮТЭЭЛ ХҮЛЭЭН АВАХ	3
ГУРАВ. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛД ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА.....	4
ДӨРӨВ. РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ.....	4
ТАВ. ШҮҮМЖ БУЮУ ХӨНДЛӨНГИЙН ХЯНАН МАГАДАЛГАА.....	5
ЗУРГАА. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛ НИЙТЛҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ШААРДЛАГА.....	6
ДОЛОО. МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ.....	6
НАЙМ. ЗОХИОГЧИЙН ЭРХ.....	7
ЕС. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЭТГҮҮЛИЙН ХЭВЛЭЛИЙН ЗАГВАР.....	7
АРАВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ.....	7
АРВАН НЭГ. ЖУРАМТ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ.....	8



НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Тус журмаар “MUST Journal of Science and Technology” эрдэм шинжилгээний сэтгүүлд бүтээл хүлээн авах, шүүмж хийх, бүтээлийг олон улсын хэмжээнд хэвлэн нийтлэх, нийтийн хүртээл болгох харилцааг зохицуулна.
- 1.2. “MUST Journal of Science and Technology” эрдэм шинжилгээний сэтгүүл нь Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн багш, судлаач, ажилтан бусад байгууллагуудын эрдэмтэн, судлаачдын шинжлэх ухааны шинэлэг судалгааны үр дүнг сурталчлах, судлаачдын чадавхыг бэхжүүлэх, эрдэм шинжилгээний үр дүн, бүтээлүүдийг (open access) англи хэлээр хэвлэн нийтлэх, түгээн дэлгэрүүлж нийтийн хүртээл болгох, хадгалах зорилготой.
- 1.3. “MUST Journal of Science and Technology” эрдэм шинжилгээний сэтгүүл нь ШУТИС-ийн оюуны өмчөөр хамгаалагдсан байна.
- 1.4. “MUST Journal of Science and Technology” эрдэм шинжилгээний сэтгүүлийг ШУТИС-ийн зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, олшруулан тараах, худалдаалахыг хориглоно.
- 1.5. “MUST Journal of Science and Technology” эрдэм шинжилгээний сэтгүүл нь олон улсын цувралын стандарт, болон цахим таних дугаартай байна.
- 1.6. “MUST Journal of Science and Technology” эрдэм шинжилгээний сэтгүүл нь бие даасан цахим хуудастай байна.

ХОЁР. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЭТГҮҮЛД НИЙТЛҮҮЛЭХ БҮТЭЭЛИЙН ТӨРӨЛ, БҮТЭЭЛ ХҮЛЭЭН АВАХ

- 2.1. “MUST Journal of Science and Technology” эрдэм шинжилгээний сэтгүүл нь шинжлэх ухаан, технологийн суурь болон хавсарга судалгаа; технологи, инженерчлэл, инновацын судалгааны чиглэлээр бүтээл хүлээн авна.
- 2.2. “MUST Journal of Science and Technology” эрдэм шинжилгээний сэтгүүлд хүлээн авах бүтээл нь дараах төрөлтэй байна. Үүнд:
 - 2.2.1. эрдэм шинжилгээний өгүүлэл (research article/full paper)
 - 2.2.2. товч өгүүлэл (short original communication and discussion article)
 - 2.2.3. судалгааны тэмдэглэл (research note)
 - 2.2.4. тойм өгүүлэл (review article)
- 2.3. Энэ журмын 2.2-т зааснаас бусад төрлийн бүтээлийг хүлээн авах эсэхийг редакцын зөвлөл шийдвэрлэнэ.
- 2.4. “MUST Journal of Science and Technology” эрдэм шинжилгээний сэтгүүлд судлаачдын бүтээлийг тогтмол хүлээж авах ба жилд 2 дугаарыг тогтоосон хугацаанд хэвлэмэл болон цахим хэлбэрээр эмхэтгэн гаргана.
- 2.5. Бүтээл хүлээн авах зар болон тухайн оны дугаарт бүтээл хүлээн авахад тасалбар болгох хугацааг цахим хуудсанд нээлттэй байршуулж мэдээлнэ.
- 2.6. Редакцын зөвлөл нь энэ журамд заасан нийтлэг шаардлага, батлагдсан загвараар бүтээлээ боловсруулж ирүүлсэн зохиогчид хүлээн авсан тухай хариу мэдэгдэж, хөндлөнгийн хянан магадалгаанд шилжүүлнэ.
- 2.7. Энэ журмын 2.6-д заасан хүлээн авсан тухай хариу ирүүлсэн хугацааг “хүлээж авсан хугацаа” гэж тооцно.
- 2.8. Редакцын зөвлөл энэ журмын 2.7-д заасан өдрөөс эхлэн 4 долоо хоногийн дотор хөндлөнгийн хянан магадалгааны шүүмжийг бүтээл ирүүлсэн зохиогчид хүргүүлэх ба шүүмж хүргүүлсэн өдрөөс 2 долоо хоногийн дотор зохиогч шүүмжийн дагуу засварыг хийж, сайжруулсан бүтээлийг редакцын зөвлөлд буцаан ирүүлнэ.
- 2.9. “MUST Journal of Science and Technology” эрдэм шинжилгээний сэтгүүл нь аливаа онцлог үйл явдалтай уялдуулан редакцын зөвлөлийн шийдвэрээр тусгай дугаар гаргаж болно.



- 2.10. Сэтгүүлтэй холбоотой асуудлаар редакцын зөвлөлтэй биеэр болон үүрэн утас, цахим хуудас, цахим шуудангийн хаягаар холбогдоно.

ГУРАВ. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛД ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА

- 3.1. Эрдэм шинжилгээний бүтээл нь дараах бүтэцтэй байна. Үүнд:
 - 3.1.1. Өгүүллийн гарчиг
 - 3.1.2. Зохиогчийн нэр, байгууллагын нэр, холбоо барих зохиогчийн цахим хаяг
 - 3.1.3. Хураангуй (Abstract)
 - 3.1.4. Түлхүүр үгс
 - 3.1.5. Удиртгал
 - 3.1.6. Судалгааны аргазүй
 - 3.1.7. Судалгааны үр дүн
 - 3.1.8. Хэлэлцүүлэг
 - 3.1.9. Дүгнэлт
 - 3.1.10. Талархал (заавал биш)
 - 3.1.11. Санхүүжилтийн эх үүсвэрийн мэдээлэл
 - 3.1.12. Зохиогчдын үүрэг, оролцоо, хувь нэмэр
 - 3.1.13. Ашиг сонирхлын зөрчилгүйн баталгаа
 - 3.1.14. Ашигласан материал
- 3.2. Эрдэм шинжилгээний бүтээл, ашигласан материалын жагсаалтыг бичихдээ редакцын зөвлөлөөр батлагдсан загварыг баримтална.
- 3.3. Энэ журмын 3.2-т заасан батлагдсан загварыг их сургуулийн болон сэтгүүлийн цахим хуудсанд нээлттэй байршуулна.
- 3.4. Эрдэм шинжилгээний бүтээл нь энэ журмын 2.1-д заасан агуулга, судалгааны чиглэлийн хүрээнд бичигдсэн байна. Энэхүү журмын 2.3 заалтын дагуу зөвшөөрөгдсөн бүтээл бол тухайн шинжлэх ухааны агуулга, судалгааны чиглэлийн хүрээнд бичигдсэн байна.
- 3.5. Эрдэм шинжилгээний бүтээлийг англи хэл дээр бичиж ирүүлнэ.

ДӨРӨВ. РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

- 4.1. "MUST Journal of Science and Technology" эрдэм шинжилгээний сэтгүүл нь судлаачдын ирүүлсэн бүтээлийг хянан хэвлүүлэх үүрэг бүхий редакцын зөвлөлтэй байна.
- 4.2. Редакцын зөвлөл нь ШУТИС-ийн эрдэмтэн судлаачид болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бусад дотоод, гадаадын эрдэмтэн судлаачдаас бүрдэх бөгөөд ШУТИС-ийн ректорын тушаалаар баталгаажуулна.
- 4.3. Редакцын зөвлөл нь Ерөнхий редактор буюу редакцын зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэх ба дарга, нарийн бичгийн даргыг редакцын зөвлөлийн гишүүдээс 3 жил тутам ээлжлэн сонгож ажиллуулна.
- 4.4. Редакцын зөвлөлийн гишүүд Ерөнхий редактор (редакцын зөвлөлийн дарга) -тай үүрэг, хариуцлага, ёс зүйн гэрээ байгуулна.
- 4.5. Редакцын зөвлөлийн гишүүдэд дараах нийтлэг шаардлага тавигдана. Үүнд:
 - 4.5.1 Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, ёс зүйн хэм хэмжээг өндөр хэмжээнд сахин мөрдөх, сэтгүүлд ирүүлж буй бүтээлтэй холбоотой мэдээллийн нууцыг задруулахгүй байх үүрэг хүлээх
 - 4.5.2 Редакцын зөвлөлийн бүх гишүүн эрдмийн зэрэг, цолтой, тухайн салбарын судалгааны чиглэлээр идэвхтэй судалгаа хийж байгаа, Web of Science, Scopus-д индекстэй сэтгүүлд бүтээлээ хэвлүүлсэн эрдэмтэн судлаач байх
 - 4.5.3 Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад ажиллаж байсан туршлагатай байхаас гадна, сэтгүүлд ирүүлж буй бүтээлийн найруулга, арга зүй, үр дүн, шинэлэг тал, дүгнэлт, шинжлэх ухааны логик уялдаа холбоог харгалзан үнэн зөв, бодит үнэлэлт дүгнэлт хийх чадвартай байх
- 4.6. Редакцын зөвлөлийн гишүүд, дотоодын шүүмжлэгч нарт ажлын үр дүнг үндэслэн ректорын тушаалаар урамшуулал олгож болно.



- 4.7. Редакцын зөвлөл дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 4.7.1 Сэтгүүлд ирүүлсэн бүтээлийн чанар, шинжлэх ухааны шинэлэг тал, онол арга зүйн түвшин, утга найруулгын алдааг зэргийг нягталж, тухайн бүтээлийг хөндлөнгийн хянан магадалгаанд шилжүүлэх эсэхийг шийдвэрлэх
 - 4.7.2 Сэтгүүлд ирүүлсэн бүтээлд хөндлөнгийн хянан магадалгаа хийх шүүмжлэгчдийг сонгох
 - 4.7.3 Хөндлөнгийн хянан магадалгаа хийх шүүмжлэгчдийн жагсаалт гаргаж, холбогдох хаягийн хамт бүртгэж хадгалах
 - 4.7.4 Хянан магадалгаа хийгдэж засвар хийсэн бүтээлийг шаардлага хангаж байгаа эсэхийг хянан хэвлэхийг зөвшөөрөх, эсвэл хэвлэхээс татгалзан буцаах
 - 4.7.5 Хянан магадалгаа хийгдсэн бүтээлд зохиогчийн зүгээс гаргасан үндэслэлтэй гомдлыг хэлэлцэж шийдвэрлэх
 - 4.7.6 Сэтгүүлд бүтээл хүлээн авах, хэвлэн нийтлэх үйл ажиллагааг байнгын, тасралтгүй, хэвийн явуулах үүрэг хүлээх
 - 4.7.7 Редакцын зөвлөл нь хараат бус, бие даасан үйл ажиллагаа явуулах бөгөөд энэхүү журмаар зохицуулагдаагүй асуудлаар дотоод үйл ажиллагааны удирдамж, зааврыг баталж, түүнийг мөрдлөг болгон ажиллана.
 - 4.7.8 Шаардлага хангасан бүтээлийг хэвлэн нийтлэхтэй холбоотойгоор зохиогчоос авах төлбөр болон сэтгүүлд нийтлүүлэх сурталчилгааны хуудасны төлбөрийн хэмжээг редакцын зөвлөлийн саналыг үндэслэн тогтоож, ректорын тушаалаар батална.
- 4.8. Ерөнхий редактор болон нарийн бичгийн дарга нь дараах чиг, үүрэг хүлээнэ. Үүнд:
- 4.8.1 Сэтгүүлд ирүүлэх өгүүллийг нарийн бичгийн дарга хүлээн авна.
 - 4.8.2 Сэтгүүлд ирүүлсэн бүтээл, түүний зохиогчтой холбоотой мэдээллийг чандлан нууцлах
 - 4.8.3 Бүтээл хүлээн авах цахим хаягийн нэвтрэх нууц үгийг задруулахгүй байх, алдахаас сэргийлэх
 - 4.8.4 ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ хариуцсан нэгжээр тухайн бүтээлийг их сургуулийн түвшинд хэрэглэгдэх албан ёсны бүтээлийн хуулбарлалт шалгах программаар шалгуулж, холбогдох журамд заасан зөвшөөрөгдөх хувь хэмжээг хангасан тохиолдолд редакцын зөвлөл рүү илгээх
 - 4.8.5 Сэтгүүлд ирүүлсэн бүтээлтэй урьдчилан танилцаж, хөндлөнгийн хянан магадалгаа хийхэд зориулан бүтээл тус бүрийн зохиогчийн нэр, холбоо барих хаяг, харьяалагдах байгууллага, талархал зэрэг хувийн мэдээллийг нууцлан, бүтээл тус бүрд тусгай дугаар (код) олгож, редакцын гишүүдэд танилцуулах
 - 4.8.6 Сэтгүүлд ирүүлсэн бүтээлд тусгай дугаар (код)-ыг "Сэтгүүлийн товчилсон нэр + Сэтгүүлийн дугаар + Сэтгүүлд бүтээл ирүүлсэн дараалал" буюу "MUST...-1" хэлбэрээр өгөх
 - 4.8.7 Урьдчилсан шалгуур хангаж буй зохиогчийн нэрийг нууцалсан тусгай дугаар (код) бүхий бүтээлийг хөндлөнгийн хянан магадалгаа хийх шүүмжлэгчид хүргүүлэх
 - 4.8.8 Шүүмжлэгч нарт зориулсан удирдамжийг боловсруулж, хөндлөнгийн хянан магадалгаа хийх шүүмжлэгчид хүргүүлэх
 - 4.8.9 Хөндлөнгийн хянан магадалгаа хийсэн шүүмж бүхий бүтээлийг зохиогчид хүргүүлж, засварласан бүтээлийг хүлээн авах

ТАВ. ШҮҮМЖ БУЮУ ХӨНДЛӨНГИЙН ХЯНАН МАГАДАЛГАА



- 5.1. "MUST Journal of Science and Technology" эрдэм шинжилгээний сэтгүүлийн редакцын зөвлөл нь судлаачдаас ирүүлсэн бүтээлд шүүмж буюу хөндлөнгийн хянан магадалгаа хийлгэнэ.
- 5.2. Хөндлөнгийн хянан магадалгаа нь давхар нууцлалтай (double blind) байна.
- 5.3. Энэ журмын 5.2-т заасан давхар нууцлалтай хянан магадалгаа нь зохиогч болон шүүмжлэгч талууд харилцан бие биеэ мэдэхгүй, зөвхөн редакцын зөвлөлийн мэдээллийн нууц хамгаалах гишүүн болох ерөнхий редактор, нарийн бичгийн дарга эдгээр талуудын илгээсэн бүтээл, шүүмжийг талуудад дамжуулах хэлбэрээр явагдана.
- 5.4. Хөндлөнгийн хянан магадалгаа хийх 2 шүүмжлэгчийг ерөнхий редактор болон редакцын зөвлөлийн гишүүд хэлэлцэж сонгоно.
- 5.5. Хөндлөнгийн хянан магадалгаа хийх шүүмжлэгч нь редакцын зөвлөлийн гишүүн байж болно.
- 5.6. Хэрэв редакцын зөвлөлийн гишүүн сэтгүүлд бүтээл ирүүлсэн бол ашиг сонирхлын зөрчилгүй байх шүүмжлэгчийг сонгоно.
- 5.7. Сэтгүүлд ирүүлсэн бүтээлтэй анхлан танилцаж байгаа тул ерөнхий редактор болон нарийн бичгийн дарга нь хөндлөнгийн хянан магадалгаа хийхгүй.
- 5.8. Хөндлөнгийн хянан магадалгаа хийж буй шүүмжлэгч бүтээлийг хүлээн авснаас 2-3 долоо хоногт багтаан шүүмжийг ирүүлнэ.
- 5.9. Хөндлөнгийн хянан магадалгааг редакцын зөвлөлөөс баталсан удирдамжийн дагуу хийнэ.

ЗУРГАА. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛ НИЙТЛҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ШААРДЛАГА

- 6.1. Зохиогч нь энэ журамтай сайтар танилцаж, холбогдох шаардлагыг баримтлах үүрэгтэй.
- 6.2. Зохиогч нь энэ журмын 3.2-д заасны дагуу сэтгүүлд ирүүлэх бүтээлийг бэлтгэнэ.
- 6.3. Зохиогч нь хэрэв өөрийн бусад бүтээлээс эшлэл авсан бол энэ нь нийт эшлэл авсан бүтээлийн 30 хувиас хэтрэхгүй байна.
- 6.4. Зохиогч нь сэтгүүлд бүтээл хүлээн авахаар зарласан хугацаанд багтаан бүтээлээ ирүүлнэ.
- 6.5. Зохиогч нь редакцын зөвлөлөөс шүүмжлэгчийн хөндлөнгийн хянан магадалгаа хийсний дагуу хүргүүлсэн санал, тухайн бүтээлийг сайжруулах зөвлөмж, чиглэлийн хүрээнд бүтээлээ дахин засварлан энэ журмын 2.8-д заасан хугацаанд ирүүлнэ.
- 6.6. Хэрэв зохиогчид хөндлөнгийн хянан магадалгаатай (шүүмжтэй) холбоотой санал, тайлбар, гомдол байвал редакцын зөвлөлд ирүүлнэ.
- 6.7. Санал, тайлбар, гомдлыг бичгээр гаргах ба зохиогчийн гарын үсгээр баталгаажсан байна.
- 6.8. Санал, тайлбар, гомдол нь бодитой үндэслэлд тулгуурласан байна.
- 6.9. Зохиогчийн сэтгүүлд хэвлүүлэхээр ирүүлж буй бүтээл нь патентын эрхийн хамгаалалт хийлгэх шаардлагатай бол сэтгүүлд ирүүлэхээс өмнө патентын мэдүүлгийг урьдчилан гаргасан байна.
- 6.10. Зохиогч нь сэтгүүлд бүтээлээ ирүүлэхдээ энэ журмын 2.2-т заасан бүтээлийн төрлөөс сонгож илгээнэ.

ДОЛОО. МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ

- 7.1. "MUST Journal of Science and Technology" эрдэм шинжилгээний сэтгүүлийн редакцын зөвлөл нь зохиогчоос бүтээл хүлээн авахаас эхлээд, шүүмж хийх, хэвлэн нийтлэх хүртэлх бүхий л харилцаанд эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээ, зарчмыг баримтлах бөгөөд ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж, зохиогчийн болон шүүмжлэгчийн мэдээллийг нууцална.
- 7.2. Нууц мэдээлэл гэдэгт зохиогч болон шүүмжлэгч талуудын хувийн мэдээлэл буюу нэр, албан байгууллага, цахим шуудангийн хаяг, гаргасан санал, тайлбар,

гомдол, хүсэлт, оюуны өмч болохын хувьд сэтгүүлд ирүүлсэн бүтээл бүхэлдээ (сэтгүүл хэвлэгдэн гарахаас өмнө), бүтээлийн бүтцэд хамаарах талархал, нууцлал зохих бусад мэдээллийг ойлгоно.

- 7.3. Сэтгүүлд ирүүлсэн бүтээлд хөндлөнгийн хянан магадлагаа хийх болон хэвлэгдэх хүртэл бүхий л үе шатанд зохиогч, шүүмжлэгч талуудын аль алинд нь нэр болон бусад хувийн мэдээллийг нууцална.
- 7.4. Энэ журмын 7.2-т заасан нууц мэдээлэлтэй зөвхөн нууц хамгаалах редакцын зөвлөлийн гишүүд (ерөнхий редактор, нарийн бичгийн дарга) танилцах эрхтэй.

НАЙМ. ЗОХИОГЧИЙН ЭРХ

- 8.1. "MUST Journal of Science and Technology" эрдэм шинжилгээний сэтгүүл, сэтгүүлийн нэр, хавтасны дизайн, сэтгүүлийн цахим хуудасны зохиогчийн эрх эзэмшигч нь ШУТИС байна.
- 8.2. Энэхүү журмын 8.1-д заасан зохиогчийн эрх эзэмшигч болох ШУТИС нь "MUST Journal of Science and Technology" эрдэм шинжилгээний сэтгүүлийг цаасан болон цахим хэлбэрээр хэвлэн нийтлэх, түгээх эрхийг эдэлнэ.
- 8.3. "MUST Journal of Science and Technology" эрдэм шинжилгээний сэтгүүлд цаасан болон цахим хэлбэрээр нийтлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээлийн зохиогчийн эрх нь тухайн бүтээлийн зохиогчид хадгалагдана.
- 8.4. Энэ журмын 8.3-т дурдсан бүтээлийн зохиогчийн эрх эзэмшигч (тухайн өгүүллийн зохиогч) нь "MUST Journal of Science and Technology" эрдэм шинжилгээний сэтгүүлийн редакцын зөвлөлд бүтээлээ ирүүлсэн бол тухайн бүтээлийг хэвлүүлэхийг зөвшөөрсөнд тооцно.
- 8.5. Бүтээлийн зохиогч нь өмнө хэвлэгдэж байгаагүй бүтээлийг ирүүлнэ
- 8.6. Бүтээлийн зохиогч нь хэрэв бүтээлдээ зохиогчийн эрхээр хамгаалагдсан бүтээл, материалыг ашигласан бол холбогдох хууль, журмын дагуу зохих зөвшөөрөл авсан байна.
- 8.7. Бүтээлийн зохиогч нь бүтээлдээ бусад бүтээлээс эшлэл авахдаа Зохиогчийн эрхийн тухай хууль, тухайн эшлэл авч буй бүтээлийн зохиогчийн бүтээлээ ашиглуулах талаар тусгайлан гаргасан мэдэгдэл, нөхцөл, ёс зүйг баримтална.
- 8.8. Хэрэв "MUST Journal of Science and Technology" эрдэм шинжилгээний сэтгүүлд ирүүлсэн бүтээлд тухайн бүтээлийн үнэн зөв байдал, зохиогчийн эрхтэй холбоотой аливаа зөрчил үүсвэл тухайн өгүүллийн зохиогч өөрөө хариуцна.
- 8.9. "MUST Journal of Science and Technology" эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлэгдсэн эрдэм шинжилгээний бүх бүтээлийг CC-BY-NC (Creative Commons Attribution-NonCommercial 4.0 International <https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/deed.en>) лицензийн дагуу ашиглуулна.
- 8.10. Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээлийг энэ журмын 8.9-д заасан нөхцөлөөр ашиглахад заавал эх сурвалжийг дурдах (эшлэл авах) үүрэг хүлээнэ.

ЕС. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЭТГҮҮЛИЙН ХЭВЛЭЛИЙН ЗАГВАР

- 9.1. "MUST Journal of Science and Technology" эрдэм шинжилгээний сэтгүүлийг 17.2 см x 24.5 см (B5) хэмжээтэй хэвлэнэ.
- 9.2. Сэтгүүлийн гадна хавтас нь хөх цэнхэр өнгө бүхий өвөрмөц дизайнтай байна.
- 9.3. Гадна хавтасны дунд хэсэгт эрдэм шинжилгээний сэтгүүлийн "MUST Journal of Science and Technology" нэрийг бүх үсгийг томоор бичиж, голлуулан байрлуулж, түүний доод хэсэгт сэтгүүлийн дугаарыг тавина.
- 9.4. Гадна хавтасны доод хэсэгт, хавтасны нүүрийг голлуулан сэтгүүл хэвлэгдэж буй оныг тавина. Жишээлбэл: 2025 он."

АРАВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 10.1. "MUST Journal of Science and Technology" эрдэм шинжилгээний сэтгүүлд бүтээл хэвлүүлэхтэй холбогдон гарсан санал, гомдол, маргааныг редакцын зөвлөл зохих

ШУТИС-ийн ректорын 2025 оны 11 дүгээр сарын
10-ны өдрийн 33 дугаар тушаалын хавсралт

хууль, дүрэм, журам болон Олон улсын "Хэвлэл нийтлэлийн ёс зүйн хороо
(COPE-Committee on Publication Ethics)"-ны гаргасан зөвлөмжийг баримтлан
шийдвэрлэнэ.



АРВАН НЭГ. ЖУРАМТ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

- 11.1. Журамд оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналыг сэтгүүлийн редакцын зөвлөл, ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ хариуцсан нэгж, бусад бүтцийн нэгжүүдээс гаргаж болно.
- 11.2. Журамд оруулах нэмэлт, өөрчлөлт нь энэхүү журмын салшгүй хэсэг болно.

--XXX--